

НООЛУУРЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНД ТӨРӨӨС БАРИМТЛАХ ХУУЛЬ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Ш.Энхтуул*, Н.Батдэлгэр**, Б.Долгормаа***, Н.Сонинтамир****,
Э.Мөнхсаруул*****, Б.Буд-Амгалан*****

Монгол улс уул уурхайн нөөцөөс гадна МАА-ын гаралтай нөөцөд суурилсан экспортын кластерыг хөгжүүлэх нь манай хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэйгөөс гадна экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм. Манай улсын цаг уурын нөхцөл байдал, мал маллагааны онцлогоос хамааран ямааны ноолуурын чанар сайтай бөгөөд нийт дэлхийн ноолуурын нөөцийн 40 хувийг Монгол улс бэлтгэн нийлүүлдэг. Гэвч дэлхийн зах зээлд анхан шатны боловсруулалт хийсэн угаасан болон самнасан ноолуурын 70-90 хувийг эзэлдэг боловч эцсийн бүтээгдэхүүний 0,1 хувийг эзэлдэг нь манай улс ноолуурын дотоод нийлүүлэлтийн сүлжээгээ дахин загварчлах шаардлага буй илтгэж байгаа юм.

Энэхүү судалгаанд судлаачдын боловсруулсан ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний зураггаад үндэслэн үндсэн болон дэмжих үйл ажиллагааг тодорхойлсон. Үндсэн үйл ажиллагаа болох түүхий эдвэс эцсийн бүтээгдэхүүн хүртээх бараа материалын болон түүхий эдийн урсгаад нэмүү өртөг хэрхэн нэмэгдэж буйг харууладаг бөгөөд манай улсын хувьд ноолуур бэлтгэн нийлүүлэлт болон анхан шатны үйлдвэрлэлийн дараагаар нийт ноолуурын 80 орчим хувийг экспортод асуудаад нийлүүлэлтийн сүлжээний дэмжих үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлэх төрийн бодлого зохицуулалтын нөлөөллийг гаргахыг зорьсон юм.

Энэхүү судалгаанд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой давхардсан тоогоор нийт 34 хууль, 52 бодлогын баримт бичгийн хүрээнд хийгдсэн бөгөөд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд төрөөс баримтлах хууль, бодлого баримт бичгүүд хэрхэн нөлөөлж буйг тухлур үгийн тусламжтайгаар текст олборлолтын аргачлалыг ашиглан энэхүү шинжилгээг хийв.

Шинжилгээний үр дүнд төрөөс барьж буй хууль, бодлогын баримт бичгийн нөлөөлөл нь нийт ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд жигд бус байгаа бөгөөд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний түүхий эд бэлтгэл болон үйлдвэрлэлийн хэсгийг голчлон дэмжиж байгаа боловч бэлтгэн нийлүүлэлт болон экспортын үйл ажиллагааны хэсгийг дэмжсэн, анхаарах хандуулсан бодлогын баримт бичиг дутагдалтай байна гэсэн үр дүнд хүрэв.

Тухлур үгс: ноолуурын кластер, бодлогын баримт бичиг, ноолуурын нийлүүлэлтийн сүлжээ

GOVERNMENT ROLE IN CASHMERE SUPPLY CHAIN IN TERMS OF POLICY FORMULATION

In addition to Mongolia's mining resources, the development of an export cluster based on resources originating from agricultural not only has a positive effect on our employment, but it is also important to increase the diversification of exports. Climate conditions and animal husbandry has positive influence to the quality of goat cashmere and Mongolia prepares and supplies 40% of the world's stock. However, we supply 70-90% of the primary processed washed and combed cashmere in the world market, but only 0.1% of the final product, indicates that our country needs to redesign its domestic cashmere supply chain.

Primary and supporting activities of cashmere supply chain has been identified by the researchers of this study. In primary activities of the cashmere supply chain includes raw material and financial flow of the production, in which our country exports 80 percent of the cashmere after washing and combing stage of production.

In the current study we try to define and evaluate the direct co-relation and impact of government policy documents and regulations to cashmere supply chain management. We collected 34 laws and 52 policy documents which are related and supports cashmere supply chain of Mongolia. Also researchers identified 108 representing key words of each stages of cashmere supply chain which were used in policy documents and analyzed using text mining methods, used by in late academic papers in recent years.

As a result of the analysis, the impact of the laws and policy documents held by the government is uneven on the entire cashmere supply chain, mainly supporting the raw material preparation and production part of the supply chain. But also concluded that there is a lack of policy documents that support and focus on intermediary operations and exporting activities.

Key words: Cashmere cluster, Policy and regulation, Cashmere supply chain

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): enkhtuuls@num.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batdelger.n@num.edu.mn

*** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): hk.dolgormaa@gmail.com

**** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): nsonintamir@num.edu.mn

***** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): munkhsaruul.e@num.edu.mn

***** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): budamgalanb@gmail.com

Судалгааны үндэслэл

Дэлхийн ямааны ноолуурын нөөцийн 55 хувийг Хятад улс, 40 хувийг Монгол улс, 5 хувийг Иран, Афганистан зэрэг улсууд бэлтгэдэг (Д.Батбаяр, 2019). Гэвч Монгол улс 2021 оны байдлаар дэлхийн зах зээлд угаасан ноолуурын 87 хувийг, самнасан ноолуурын 73 хувийг, ноолууран ээрмэл утасны 0,16 хувийг, ноолууран бэлэн бүтээгдэхүүнийг 0,1 хувийг нийлүүлж байна. Энэхүү тоо баримтаас харахад, манай улс дэлхийд ноолуурын бэлтгэн нийлүүлэгч улс болохыг харуулж байгаа бөгөөд цаашдаа дотооддоо ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн болгон хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг томьёолоход ХАА, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр агуулах зэрэг салбаруудыг хамарсан ХАА-н гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо болон гадаад/дотоод худалдааны үйл ажиллагааг багтаасан цогц ойлголт юм.

1990 онд хүртэл мал сүргийн тоо толгойг улс ардын аж ахуйн төлөвлөлтөд суурилан хөгжүүлж байсан ба түүхий эд бэлтгэлийн тогтолцоо ч төрийн оролцоотойгоор боловсруулах үйлдвэрлэлтэй холбогддог байсан. Харин 1990 оноос эхлэн мал сүрэг хувийн өмчид шилжин, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо албан бус бизнесийн хэв шинжтэй болон шилжиж буй энэ үед мал сүргийн тоон өсөлт нь байгаль орчин, бэлчээрийн тэнцвэртэй байдал алдагдахад хүргэж байгаагаас гадна, ХАА-н гаралтай түүхийг эдийг бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог гадаад/дотоод санхүүжилттэй албан бус бизнес төлөөлөн сүүлийн 30 гаруй жил авч явж байна.

Ноолуурын эцсийн бүтээгдэхүүний хувь хэмжээг нэмэгдүүлэх нь ноолуурын кластерын оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхол хэвээр байгаа бөгөөд энэхүү судалгааны хүрээнд төрийн бодлогоор хэрхэн ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг хэрхэн дэмжин буйг, цаашид дэмжлэг шаардлагатай байгаа үе шатуудыг тодорхойлох зорилготой юм.

Зорилгын хүрээнд төрөөс баримталж буй хууль ба бодлогын баримт бичгүүд нь ноолуурын кластерын өрсөлдөх чадвар нөлөөлж байна гэж үзэж байгаа бөгөөд нийлүүлэлтийн сүлжээг цогцоор нь дэмжихгүй байна гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

Төрийн бодлогоор баримт бичигт холбогдох хууль, бодлого төлөвлөлтийн хуулийн хүрээнд хүчин төгөлдөр бодлогын баримтууд бичгүүд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн нөлөөлж буйг текст олборлолтын (text mining) аргачлалын дагуу холбогдох түлхүүр үгийн тусламжтайгаар тодорхойлсон юм.

Судалгааны зорилго, арга зүй

Нийлүүлэлтийн сүлжээнд төрийн бодлого хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохдоо дараах судалгааны аргачлалыг ашигласан болно. Ху нар хийсэн судалгаагаар (2022) Хятадын барилгын салбарт текст олборлолтын аргыг ашиглаж 1997-2022 он хүртэлх барилгын салбарт хамаарах SCOPUS мэдээллийн санд байрласан 185 өгүүлийг, гар аргаар түлхүүр үгийн шинжилгээ хийсэн байна. Тэд текст олборлолтын аргыг эрдэм шинжилгээний өгүүллүүдийг үнэлэхэд хэрэглэж, судалгааны арга барил, судалгааны загвар болон хэрэглэгдэж буй талбараар нь ангилж үр дүнд нь Хятадын барилгын салбарын өнөөгийн судлагдсан байдал болон цаашдын судалгааны сэдвүүдийг тодорхойлсон. (Wu 2022) Хятад улсын сүүлийн 20 жилийн хугацаанд онцгой байдлын менежментэд гарсан өөрчлөлтийг текст олборлолтын арга, машин сургалтын аргыг ашиглан хийсэн бөгөөд 2003-2021 оны нийтлэгдсэн 1,110,000 хятад тэмдэгтэй тэнцэх 5810 нийтлэлд дүн шинжилгээ хийж, 35 сэдвээр судалсан. Судалгааны үр дүнд сүүлийн хорин жилд Хятадад болсон онцлох үйл явдлууд болон тэдгээртэй холбоотой менежментийн өөрчлөлтүүдийн зураглалыг гаргаж, дараагийн жилүүдэд хийх судалгааны сэдвүүдийг таамагласан байна.

Харин Chih-Yuan Chu, нар 2019 Нийлүүлэлтийн сүлжээний бүс нутгийн ялгаатай эрсдэлүүдийн тухай судалгааг текст олборлолтын аргаар хийж нийт 8 эрсдэлт хүчин зүйлсийг гаргаж ирсэн. (Liu нар 2022) Олон улсын нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийн менежментийн судалгааны сэдвүүд болон судалгааны загварын хувьслыг харуулах зорилгоор 2000-2022 оны хооронд судлагдаж Citespace дээр нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд дээр анализ хийсэн. Үүний үр дүнд нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хөгжлийг 4 үед хувааж үзэн хөгжлийн чиг хандлагыг шинээр тоймлосон байна. Үүнээс гадна тэд сэтгүүл, зохиогч, улс орон, судалгааны институт зэргээр ялгахдаа machine-learning арга ашигласан нь текст олборлолтын судалгааны арга дизайныг сайжруулсан юм.

(Tong Zhang нар 2019) Төрийн бодлого боловсруулалтад текст олборлолтын аргыг ашиглан хэрхэн зорилтот бүлгэмд хэрэгтэй бодлогын бичиг баримт боловсруулах талаар 3 алхамт аргыг санал болгосон. Текст олборлолт нь бодлогын баримт бичиг, зохицуулалтын тайлан зэрэг их хэмжээний текст мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд хэрэглэгддэг аргачлал юм. Энэ нь бодлогын баримт бичгүүдийн гол сэдэв, чиг хандлага, хэв маягийг тодорхойлоход тусалж, салбарын нийлүүлэлтийн сүлжээнд засгийн газрын бодлого нөлөөллийг тодорхойлж өгөх болно. Текст олборлолт нь их хэмжээний текст өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд шаардагдах цаг хугацаа, нөөц зэрэг уламжлалт гарын авлагын аргуудын хязгаарлалтыг даван туулахад тусалдаг. Нэмж хэлэхэд, уламжлалт

аргууд нь өгөгдлийн субъектив тайлбарлах боломжтой бол үүнтэй харьцуулахад текст олборлолт нь илүү бодитой, шударга үр дүнг өгөх боломжтой. Текст олборлолт нь салбарын нийлүүлэлтийн сүлжээнд засгийн газрын бодлого нөлөөллийг судлахад хамгийн тохирсон аргачлал юм гэж тодорхойлсон байна.

Тиймээс, текст олборлолт нь салбарын нийлүүлэлтийн сүлжээнд төрийн бодлого нөлөөллийг судлахад хамгийн тохирсон аргачлал хэмээн сонгон нийлүүлэлтийн сүлжээний үе шатуудыг төлөөлөх түлхүүр үгийн давтамжид үндэслэн нөлөөллийг тодорхойлохоор зорив.

МУ-ын ноолуурын өртгийн сүлжээний зураглал

Монгол улсын түүхий ноолуурын гарцын хэмжээ жил ирэх тусам өсөж, 2021 онд 10,944 тонн түүхий ноолуурыг улсын хэмжээнд үйлдвэрлэсэн статистик мэдээлэл гарсан байна. Манай улсын ноолуурын нийт үйлдвэрлэлийн хэмжээ ямааны тоо толгойн өсөлтөөс шалтгаалан жилээс жилд нэмэгдэж байгаа нь ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хангалттай хэмжээний түүхий эд олж авах боломжийг олгож байна. Ямааны ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээний талаарх статистик мэдээллийг гаргасан 2010 оноос 2019 оныг хүртэл нийт түүхий ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ 67%-иар өссөн байна (Хүснэгт 1). Гэсэн хэдий ч ДНБ-ний салбарын бүтцийн хувьд авч үзвэл, боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь сүүлийн 10 жилд ердөө 2.6 % өссөн байна (ҮСХ, 2019). Ингэж, ямааны тоо толгой, ноолуурын гарцын хэмжээ нэмэгдэж буй хэдий ч ноолуурыг 80 орчим хувийг анхан шатны боловсруулалт хийж гадаад зах зээлд экспортолж байгаатай холбоотойгоор ноолуур боловсруулах үйлдвэрлэл бүрэн ажиллаж, нэмүү өртөг дотооддоо шингээж чадахгүй байна гэж дүгнэж болно.

Хүснэгт 1. Монгол улсын малын тоо толгой (1,000 толгой), түүхий ноолуур үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)

Он	Нийт малын тоо	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Ноолуур
1980	23,769	591	1,985	2,397	14,230	4,566	-
1990	25,856	538	2,262	2,848	15,083	5,125	-
2000	30,224	322	2,660	3,097	13,876	10,269	-
2010	32,730	270	1,920	2,176	14,480	13,883	6,516
11	36,336	280	2,113	2,340	15,669	15,935	5,472
'12	40,921	306	2,330	2,585	18,141	17,559	6,326

'13	45,144	321	2,619	2,909	20,066	19,228	7,010
'14	51,983	349	2,996	3,414	23,215	22,009	7,727
'15	55,980	368	3,295	3,780	24,943	23,593	8,858
'16	61,549	401	3,635	4,081	27,857	25,575	9,450
'17	66,219	434	3,940	4,388	30,110	27,347	10,248
'18	66,460	460	3,940	4,381	30,555	27,125	10,945
19	70,969	472	4,215	4,753	32,267	29,262	10,944
20	67,068	472	4,094	4,732	30,049	27,720	-
21	67,344	454	4,324	5,022	31,087	26,456	-

Эх сурвалж: ҮСХ, 1980-2019 оны статистик мэдээлэл

Тайлбар: ҮСХ-ны мэдээллийн санд 2010 оноос өмнөх болон 2019 оны хойших үйлдвэрлэсэн ноолуурын хэмжээний талаарх мэдээллийг оруулаагүй байгаа болно.

2021 оны байдлаар угаасан ноолуур 6017.33 тн, самнасан ноолуур 419.26 тн үүнийг түүхий рүү шилжүүлсэн хэмжээгээр нийт 9434.71 тн ноолуур экспортолсон байна (ГЕГ, 2022). Өөрөөр хэлбэл нийт үйлдвэрлэсэн түүхий ноолуурын 85 гаруй хувийг анхан шатны боловсруулалт хийж экспортолсон байна.

Хүснэгт 2. Угаасан болон самнасан ноолуурын экспортын тоон хэмжээ ба үнэ (2015-2021 он)

Он	Угаасан ноолуурын экспорт			Самнасан ноолуурын экспорт			Нийт экспортлосон ноолуур (тонн)
	Тонн	Үнэ (кг/\$)	Түүхий ноолуур руу шилжүүлсэн дүн	Тонн	Үнэ (кг/\$)	Түүхий ноолуур руу шилжүүлсэн дүн	
2015	4,988.22	39.5	7,126.03	559.05	72.8	1,118.10	8,244.13
2016	5,413.46	35.6	7,733.52	508.26	65.2	1,016.52	8,750.04
2017	5,409.69	38.0	7,728.13	584.50	66.0	1,169.01	8,897.14
2018	5,286.61	47.7	7,552.30	637.23	85.5	1,274.46	8,826.76
2019	5,688.70	49.8	8,126.72	553.19	81.8	1,106.38	9,233.09
2020	6,339.84	29.2	9,056.92	255.50	65.9	511.00	9,567.92
2021	6,017.33	42.1	8,596.18	419.26	94.9	838.52	9,434.71

Эх сурвалж: ГЕГ, 2022 он

Дээрх хүснэгтээс харахад, ноолуурын нөөцийн боловсруулах үйлдвэрийн нэмүү өртөг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн сүлжээний дэд бүтцийг боловсронгуй болгох нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Манай улс ноолуурын нөөцөөрөө дэлхийд 2 дугаарт ордог улс орон боловч нийт ноолуурын 80 гаруй хувийг анхан шатны боловсруулалт хийн экспортолдог тухай дурдсан билээ. Үлдсэн 20 хувь буюу 2000 орчим тонн ноолуурыг гүн боловсруулалт хийн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод болон гадаад зах зээлд борлуулдаг. Манай улсын экспортын бараа бүтээгдэхүүний багцыг харвал нийт экспортын 94 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 4 хувийг нэхмэл бүтээгдэхүүн эзэлдэг (ҮСХ, 2023).

Нэхмэлийн салбарын нэмүү өртөг шингээх процесс нь шат ахих тусам нэмэгддэг тул түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн болох бүхий л процесс буюу ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг цогцоор нь анхааран, чадавхжуулах нь чухал болоод байна.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг эцсийн бүтээгдэхүүнд чиглүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал байдаг талаар кластерын хөгжлийн загварыг баримтлагчид олон судалгаандаа дурдсан байдаг.

Манай улсын ноолуурын кластерт 1) ноолууран түүхий эд үйлдвэрлэгч малчид, 2) бэлтгэн нийлүүлэгч болох хоршоод, ченжүүд, 3) анхан болон гүн боловсруулах үйлдвэрүүдээс гэсэн үндсэн оролцогч талуудаас гадна 4) санхүүгийн байгууллагууд, 5) сургалт, судалгааны байгууллага, 6) салбарын мэргэжлийн холбоод, 7) төрийн байгууллага гэсэн дэмжигч оролцогч талууд байдаг гэж тодорхойлж болохоор байна.

Манай улс 1990 он төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан ба төрийн бодлогоор нийлүүлэлтийн сүлжээг удирддаг байсан ба сүүлийн 30 гаруй жил хувийн өмчит давамгайлсан компани, АНН, хувь хүмүүс эдийн засгийн харилцааг удирдан авч явж байгаа билээ. Дээрээс доошоо (top-down) эсвэл доороос дээшээ (bottom-up) чиглэлтэй хөгжлийг тодорхойлж байгаа нь ноолуурын кластерын эсвэл ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний хувьд тодорхойгүй байна. Ноолуурын кластер эсвэл ноолуурын нийлүүлэлтийн сүлжээ гэдгээс илүүтэйгээр ноолуур гэсэн түүхий эдийг манай улс дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд угаасан, самнасан ноолуурын нийлүүлэгч байх уу, эцсийн бүтээгдэхүүний нийлүүлэгч байх уу гэдэг нь илүү чухал юм. Тийм учраас, энэхүү судалгаагаар төрөөс баримталж буй бодлогыг хууль болон бодлогын баримт бичгүүд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зорилготой юм.

Нийлүүлэлтийн сүлжээ гэдэг нь түүхий эд бэлтгэн нийлүүлэгчээс үйлдвэрүүд болон бөөний төвүүдийг дамжин эцсийн хэрэглэгчид очиж байгаа материал, мэдээлэл, үйлчилгээний урсгал юм (Chopra, 2019). Нийлүүлэлтийн сүлжээ нь эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, мэдээлэл, үйлчилгээг бий болгон

хүргэдэг процесс болон байгууллагыг багтаадаг. Энгийнээр хэлбэл, эцсийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааны сүлжээ юм. Энд худалдах, төлбөрийн урсгал, материал боловсруулалт, үйлдвэрлэлийн төлөвлөлт ба хяналт, логистик болон хадгалалт, техник тоног төхөөрөмжийн хяналт, хуваарилалт болон хүргэлт зэрэг олон үйл ажиллагааг агуулдаг.” (Hugos, 2018).

Нийлүүлэлтийн сүлжээ нь хэрэглэгчийн хүсэлт, хэрэгцээг биелүүлэхэд шууд болон шууд бусаар оролцох бүх оролцогч талуудаас бүрдэх систем юм. Өөрөөр хэлбэл, түүхий эд, бэлтгэн нийлүүлэгчээс эхлээд үйлдвэрлэгч болон тээвэрлэлт, хадгалалт, бөөний болон жижиглэн худалдаагаар дамжин хэрэглэгчид очиж байгаа материал, мэдээлэл, үйлчилгээний урсгалын нэгдлийн хэлдэг.

Харин салбарын эсвэл компанийн нийлүүлэлтийн сүлжээнд нэмүү өртөг хаана бий болгож байгааг үнэлэх, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлж болохыг тодорхойлж буйг өртгийн сүлжээний шинжилгээ гэдэг.

Өртгийн сүлжээ нь компани зах зээлд урт хугацааны тогтвортой өрсөлдөөний давуу талыг бүтээх, хадгалах зорилготой. Өртгийн сүлжээ гэх ойлголтыг анх М.Портер нэвтрүүлсэн бөгөөд салбар эсвэл ихэвчлэн компани орцыг гарц болгох үйл явцад нэмүү өртөг хэрхэн бүтээж буйг задлан шинжилдэг. Өртгийн сүлжээний үйл ажиллагааг үндсэн болон дэмжих гэж хуваан үздэг (Зураг 1). Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээг өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн дараах зураглалыг гаргав.

Зураг 1. Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээний зураглал





Эх сурвалж: Судлаач боловсруулав.

Өртгийн сүлжээний үндсэн үйл ажиллагааг нийлүүлэгчид чиглэсэн урсгал болон хэрэглэгчид чиглэсэн урсгал гэж хоёр хуваан авч үздэг. Нийлүүлэгчид чиглэсэн урсгалд түүхий эд, материалын нийлүүлэлт, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо болон агуулах тээвэрлэлт болон боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг оролцуулан тооцно. Харин хэрэглэгчид чиглэсэн урсгалд гадагшаа чиглэсэн логистик, маркетинг, борлуулалт болон борлуулалтын дараах үйл ажиллагааг багтаадаг.

Өртгийн сүлжээний дэмжих үйл ажиллагаанд салбарын эсвэл компанийн технологийн дэвшил, бараа материал худалдан авалт, хүний нөөцийн менежмент, санхүүгийн үйлчилгээ болон төрийн бодлогоор хэрхэн нөлөөлж буй талаар авч үздэг.

Өртгийн сүлжээг дэмжих үйл ажиллагаанууд үндсэн ажиллагаанаас дутахгүйгээр салбарын өрсөлдөх чадварт чухал нөлөөг үзүүлдэг. Манай улсын ноолуурын өртгийн сүлжээний үндсэн үйл ажиллагааг 100% хувийн өмчит компаниуд, хувь хүмүүс авч явдаг. Малчдад ноолуурын үнэ өндөр байх нь чухал байдаг бол үйлдвэрлэгчдэд түүхий эдийн зардал нийт зардлын 70 хувийг эзэлдэг тул томоохон сорилтуудын нэг бөгөөд эргэлтийн хөрөнгийн дутагдалтай байдлаас шалтгаалан боловсруулах үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлын ашиглалт салбарын хэмжээнд 50 хувь байгаатай шууд холбоотой юм. Малчдыг үйлдвэрлэгчидтэй холбож өгч буй гол тоглогчид бол ченжүүд, хоршоод, үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид байдаг. Эдгээр холбогчдын санхүүжилтийн ихэнх хувь нь БНХАУ-аас байдаг тул нийт ноолуурын 80 хувийг худалдан авч угаасан байдлаар экспортлогдоход хүрдэг. Тийм учраас манай улс дэлхийн нийт угаасан ноолуурын 90 хувийг нийлүүлэгч улс болдог юм.

Тиймээс, өртгийн сүлжээний үндсэн үйл ажиллагааг дэмжин ажиллах дэмжих үйл ажиллагаа маш чухал юм. Ноолуурын эцсийн бүтээгдэхүүний хувь хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүжилт, технологийн дэвшил, хүний нөөцийн хүрэлцээтэй байдал болон ноолуурын бүтээгдэхүүнийг боловсруулан үйлдвэрлэх явцад тоног төхөөрөмж, химийн туслах материал зэрэг бүтээгдэхүүний худалдан авалтаас гадна төрийн бодлого, чиглүүлэг, идэвхжүүлэлт чухал ач холбогдолтой

байна. Тиймээс, энэхүү судалгааны хүрээнд төрийн бодлого ноолуурын өртгийн сүлжээний үндсэн үе шатуудад хэрхэн нөлөөлж буйг нарийвчлан судлав.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд төрөөс баримталж буй хууль, бодлогын баримт бичгийн харилцан хамаарал

Монгол улсын үндсэн хуулийн 25 зүйлд зааснаар хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж заажээ (*МУ-ын Үндсэн Хууль, 1992*). Манай улсад хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль 2015 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” нэртэйгээр батлагдаж байсан бол 2020 онд “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль нэртэйгээр шинэчлэгдэн батлагдсан байна.

Тус хуулийн өөрчлөлт нь бодлогын баримт бичгүүдийн нэр төрөл болон тэдгээрийн хоорондоо уялдаа холбоо ялгаатай байхад нөлөөлсөн бөгөөд эдгээр жилүүдэд хэрэгжсэн, хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн өөрчлөгдсөнийг энэ хэсэгт судлах юм.

2015 онд батлагдсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 4.1-д зааснаар, мөн 2020 онд батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 4.1-д зааснаар хөгжлийн баримт бичгийн нэр төрөл тус бүр 11 байна. Эдгээр хуулиудад тусгасан бодлогын баримт бичгүүдийн хэрэгжих хугацаанаас хамаарсан нэр төрлийг Хүснэгт 3 болон Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 3. 2015 оны хуулийн хөгжлийн баримт бичгүүдийн нэр төрөл, тэдгээрийн хэрэгжих хугацаа

Хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа		Бодлогын баримт бичгийн төрөл
Урт хугацааны бодлогын баримт бичиг	15-20 жил	1	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал
Дунд хугацааны бодлогын баримт бичиг	8-10 жил	2	Төрөөс баримтлах бодлого
		3	Бүсчилсэн хөгжлийн бодлого
		4	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт
	3-5 жил	5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
		6	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
		7	Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр
Богино хугацааны бодлогын баримт бичиг	1 жил	8	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
		9	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
		10	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
		11	Тус хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс судлаач эмхэтгэв.

Хүснэгт 4. 2020 оны хөгжлийн баримт бичгүүдийн нэр төрөл, тэдгээрийн хэрэгжих хугацаа

Хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа	№	Нэр төрөл	Нэршил
Урт хугацааны бодлогын баримт бичиг		1	Урт хугацааны хөгжлийн бодлого	Алсын хараа
Дунд хугацааны бодлогын баримт бичиг	10 жил	2	Хөгжлийн зорилгот хөтөлбөр	Хүний хөгжлийн ЗХ
				Нийгмийн хөгжлийн ЗХ
				Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн ЗХ
				Байгаль орчны ЗХ
				Засаглалын ЗХ
				Бүсийн хөгжлийн ЗХ Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ЗХ
Дунд хугацааны бодлогын баримт бичиг	5 жил	3	МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	
		4	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	
	4 жил	5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	
		6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	
		7	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	
		8	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөгөө	
		9	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	

Богино хугацааны бодлогын баримт бичиг	1 жил	10	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	
		11	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө	


Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс судлаач эмхэтгэв.

Дээрх хүснэгтүүдээс харахад, бодлого төлөвлөлтийн хуулиудын хүрээнд гарсан бодлогын баримт бичгийн нэр төрөл, хугацаа болон хоорондын хамааралд ихээхэн өөрчлөлт гарсныг илтгэж байна.

2020 оны шинэчилсэн “Бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай” хуулийн хүрээнд урт хугацааны бодлогын баримт бичгийн хугацаа уртсан 30 жил болсон байна. Харин дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүд нэршлийн тодорхой болгосноороо улсын хэмжээнд хөгжлийн чиглэлийг тодорхой болгон, нөөцийн хуваарилалт болон үйл ажиллагааг давхардал буурах давуу талтай болжээ гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

2020 оны хууль шинэчлэгдэх хүртэл ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд хамааралтай хууль 14, бодлогын баримт 33 байсан бол хууль шинэчилсэн хувилбараар 2023 оны байдлаар зарим хууль, бодлогын баримт бичиг шинэчлэгдсэн, нэмэгдсэн эсвэл хүчингүй болсонтой холбоотойгоор 20 хууль, 19 бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд: Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг-4, Төрөөс баримталж буй бодлого-8, Таван жилийн үндсэн чиглэл-1, Засгийн газрын хөтөлбөр-1, жилийн хөгжлийн төлөвлөгөө-1, бусад-3 байна. Хуулийн шинэчлэлийн өмнө болон дараах бодлогын баримт бичгүүдийн төрөл болон нэршлээр нь Зураг 2-г харуулав.

Зураг 2. Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд хамааралтай бодлогын баримт бичгүүдийн өөрчлөлт, 2020 оноос өмнө ба дараа



Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс судлаач эмхэтгэв.

Зураг 2-т үзүүлснээр 2020 онд батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль батлагдсанаар үндэсний хөтөлбөрүүд хүчингүй болсон байна. Харин өнөөдрийн байдлаар хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд боловсруулагдаагүй байна. Урт хугацааны бодлогын баримт бичиг болох Алсын хараа-2050-г 2020 онд баталсан бөгөөд үүнтэй холбоотойгоор 5 жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын хөтөлбөрийг батлагдсан. Харин хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн чиглэл хуульд тодорхой зааж өгсөн боловч ноолуурын салбарын хөгжил, өрсөлдөх чадвар нь байгаль орчны, эдийн засгийн болон дэд бүтцийн, бүсийн хөгжлийн, үндэсний өрсөлдөх чадварын нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрөөс хамаарах тул төрийн зүгээс стратегийг тодорхойлоогүй байна.

Бодлого төлөвлөлтийн хуулийн шинэ, хуучин хуулийн хүрээнд хэрэгжиж байсан нийт бодлогын баримт бичиг болон хуулиуд ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрд нь хэрхэн нөлөөлж буй нөлөөг 108 түлхүүр үгийн тусламжтайгаар текст олборлолт хийв. Эдгээр түлхүүр үгсийн сонголтыг нийлүүлэлтийн сүлжээний онолын хүрээнд байх шаардлагатайг харгалзахын зэрэгцээ манай улсын бодлогын бичиг баримтад хэрхэн тусгагдаж буй утга, үгийн сонголтыг харгалзан үзсэн юм. Мөн нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь хамарсан өрсөлдөх чадвар, кластер, хөрөнгө оруулалт, ажлын байр, инновац гэх зэрэг 28 үгсийн жагсаалтыг тусад нь үүсгэсэн болно.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний хөгжлийн үе шат бүрд нөлөөлөх дараах үгсийг тусад нь бүлэг үүсгэн тоололтыг гүйцэтгэсэн юм. Тоололтын үр дүнг Хүснэгт-4-т үзүүлэв.

Хүснэгт 5. Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний хөгжилд бүхэлд нь нөлөөлөх түлхүүр үгсийн хууль, БББ-д тусгагдсан давтамж

№	Түлхүүр үгс	Түлхүүр үг томъёологдсон хууль, БББ-ийн тоо	Нийт давтамж	№	Түлхүүр үгс	Түлхүүр үг томъёологдсон хууль, БББ-ийн тоо	Нийт давтамж
1	татвар/ чөлөөлөлт	23	850	15	ажлын байр	23	91
2	тогтвортой	35	239	16	хөнгөлөлт	27	87
3	судалгаа	36	236	17	менежмент	20	82
4	стандарт	34	234	18	кластер	16	76
5	хөрөнгө оруулалт	37	225	19	шинэчлэл	18	75
6	сургалт	38	218	20	хүний нөөц	20	55
7	дэмжлэг	23	148	21	мэдээллийн сан	16	38
8	шинжлэх ухаан	29	132	22	импортыг орлох	14	28
9	мэдлэг	35	131	23	ёс зүй	8	22
10	эрсдэл	25	123	24	экспортыг дэмжих	9	19
11	ноолуур	13	116	25	техникийн зохицуулалт	5	9
12	мэргэжил	33	112	26	шинэ бүтээгдэхүүн	5	5
13	өрсөлдөх чадвар	27	106	27	борлуулалтын сүлжээ	3	4
14	инноваци	27	103	28	нийлүүлэлтийн сүлжээ	3	3

Эх сурвалж: Түлхүүр үгсийн жагсаалтыг судлаач эмхэтгэв.

Эдгээр үгсийн хамгийн ихээр тусгагдсан үгс болох татвар, тогтвортой, судалгаа, стандарт, хөрөнгө оруулалт, сургалт зэргээс дүгнэхэд манай улс бүтээмж болон инновац, мэдлэг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавьж байгаа нь харагдаж байна. Харин борлуулалт, экспорт, шинэ бүтээгдэхүүн гэх зэрэг үгсийг хууль болон бодлогын баримт бичигт ашиглах нь эрс бага байгаа нь экспортод чиглэсэн бодлого дутагдаж байгаа нь илэрхий харагдаж байна.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний үе шатууд болох түүхий эд нийлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэл, борлуулалт гэх гол үе шатуудад түлхүүр үгсийг хуваан, Хүснэгт-5 харуулав.

Хүснэгт 6. Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний үе шат, төлөөлөх түлхүүр үгсийн жагсаалт

Малчин		Бэлтгэн нийлүүлэгч		Үйлдвэрлэгч		Хэрэглэгч, борлуулалт	
1	малчин/малчдын	1	Хоршоо	1	Үйлдвэрлэл	1	Хэрэглэгч
2	Чанар	2	Хамтын ажиллагаа	2	Технологи	2	Зах зээл
3	Бэлчээр	3	Хадгалалт	3	боловсруулах үйлдвэр/ү	3	Брэнд
4	Бэлчээрийн даац	4	Тээвэр	4	хөнгөн үйлдвэр	4	Хуудалдаа
5	Экологи	5	Борлуулалт	5	Цогцолбор үйлдвэр	5	Гадаад худалдаа
6	Эрүүл ахуй	6	Нийлүүлэлт	6	Гүн боловсруулах үйлдв	6	Бүтээгдэхүүн
7	Үүдэр	7	бирж	7	Анхан шатны үйлдвэр	7	Эцсийн бүтээгдэхүүн
8	Эрчимжсэн мал аж ахуй	8	Бэлтгэн нийлүүлэгч	8	Эргэлтийн хөрөнгө	8	Санхүүгийн эх үүсвэр
9	Бэлчээр ашиглалт	9	Бүс нутаг	9	Нэмүү өртөг	9	Экспорт
10	бордоо	10	агуулах	10	Дэвн боловсруулах	10	орлох бүтээгдэхүүн
11	бэлчээрийн мал аж ахуй	11	орон нутаг	11	аж үйлдвэр	11	тариф
12	бэлчээрийн менежмент	12	малчдын бүлэг	12	бүтээмж	12	чанарын баталгаа/тэмдэг
13	тэжээл	13	түүхий эд	13	нэмүү өртгийн	13	зорилгот зах зээл
14	фермер/ферм	14	нөхөрлөл	14	техник	14	завсрын бүтээгдэхүүн
15	малын эрүүл мэнд	15	түншлэл	15	тоног төхөөрөмж	15	гадаад зах зээл
16	уламжлал	16	хадгалах	16	үр ашиг	16	гадаад худалдааны гэрээ/ хэлэлцээр
17	малын тоо	17	бэлтгэн нийлүүлэх	17	чадавх	17	сав баглаа боодол
18	Үржил селекц	18	Бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо	18	өртгийн сүлжээ/үнэ цэн	18	логистик
19	ядуурал	19	албан бус хөдөлмөр эрхлэлт	19	Туслах материал	19	загвар дизайн
20	ямаа	20	зуучлагч	20	дэмжих үйлдвэрлэл/сал	20	Маркетинг

Эх сурвалж: Түлхүүр үгсийн жагсаалтыг судлаач эмхэтгэв.

2015 оны “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль хүчин төгөлдөр байх үеийн 14 хууль, 33 бодлогын баримт бичиг болон 2020 онд батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн хүрээнд хэрэгжиж буй 19 бодлогын баримт бичиг, 20 хуулийг оролцуулан түлхүүр үгсийн давтамжийг тус бүрээр тоололт хийн, түлхүүр үг тус бүр нэгж бодлогын бичиг баримтад хэдэн удаа тусгагдсан тоог нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрийн хэдэд нь тусгагдсан байгаад харьцуулан, ач холбогдлын зэрэглэлд dummy variable ашиглан тооцоолол хийсний үр дүнд дараах үр дүнд хүрэв.

Энэхүү судалгааг хийх явцад бодлого төлөвлөлтийн 2 хууль хэрэгжсэн

байгаа бөгөөд тус хуулиудын хүрээнд хэрэгжиж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хоорондын хамаарал, тоо, агуулга өөр өөр байгаа боловч ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний хувьд бүхэлд нь эсвэл тасралттай байгаа хэсэгт нь нөлөөлсөн нөлөөлөл бага байна.

Хууль болон бодлогын баримт бичигт тусгагдсан үгсээр тоололт хийхэд түүхий эд бэлтгэн нийлүүлэгч (МАА) болон боловсруулах үйлдвэрлэл рүү чиглэсэн бодлого харьцангуй их байгаа боловч МАА-г боловсруулах үйлдвэрлэлтэй холбох бэлтгэн нийлүүлэгчдэд чиглэсэн бодлого, чиглүүлэг шаардлагатай байна. Энэ хэсгийг анхааралдаа авснаар нийт түүхий эдийн нөөцийн боловсруулах түвшинг дотооддоо нэмэгдүүлэх нь нэмүү өртөг шингэх, ажлын байрыг үүсгэхээс гадна экспортын орлогыг нэмэгдүүлэх зангилаа нь юм.

Дээрх 2 хуулийн хүрээнд хэрэгжиж буй ний давхардсан тоогоор 34 хууль, 52 бодлогын баримт бичигт тусгагдсан түлхүүр үгийн тоололтыг хийхэд дараах үр дүн гарсан юм. (Зураг 3.)

Зураг 3. Бодлогын бичиг баримтуудад түлхүүр үгний үндсэн хийгдсэн тоололтын бүдүүвч

ТҮЛХҮҮР ҮГС					
Түүхий эд үйлдвэрлэл (малаж ахуй)	Бөөний худалдаа, тээвэр (чөлж, бирик)	Үйлдвэр, компаниуд	Тээвэр, логистик, экспорт	Живчилсэн худалдаа	Зах зээл, хэрэглэгч
<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүн Хоршоо Түүхий эд Малчин, малчдын Ноолуур Бэлчээр Бүс нутаг, орон нутаг Үүдэр Эрчимжсэн малаж ахуй Ямаа гэх мэт 	<ul style="list-style-type: none"> Хоршоо Тээвэр Бирик Нийлүүлэлт Зуучлагч Бэлтгэн нийлүүлэх Бэлтгэн нийлүүлэгч Бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо гэх мэт 	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэл Бүтээгдэхүүн Технологи Чанар Стандарт Сургалт Хоронго оруулалт Орсодох чадвар Брэнд гэх мэт 	<ul style="list-style-type: none"> Экспорт Худалдаа Тээвэр Агуулах Гадаад худалдаа Нийлүүлэлт Хадгалалт Логистик Экспортыг дэмжих Борлуулалтын сүлжээ гэх мэт 	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүн Худалдаа Эцсийн бүтээгдэхүүн Өртгийн үнэ цэнийн гинжийн хэлхээ 	<ul style="list-style-type: none"> Зах зээл Стандарт Хэрэглэгч Борлуулалт Зорилгот зах зээл Гадаад зах зээл Өртгийн сүлжээ/үнэ цэнийн гинжийн хэлхээ
181.4	40	179.3	52	37.5	26.7
203	42.8	188.9	51.2	38.4	32.6

Эх сурвалж: Судалгааны үр дүнг зохиолч нэгтгэв.

Дээрх зурагт харуулсны дагуу 2015 оны хуулийн хүрээнд хэрэгжсэн бодлогын баримт бичгүүд түүхий эд үйлдвэрлэл 181,4, бөөний худалдаа, тээвэр

40, боловсруулах үйлдвэрлэл 179,3, тээвэр логистик экспорт 52, жижиглэн худалдаа 37,5, зах зээл хэрэглэгч 26,7 гэсэн утгатай байна. Харин 2020 оны шинэ хуулийн хүрээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд түүхий эд үйлдвэрлэл 203, бөөний худалдаа, тээвэр 42,8, боловсруулах үйлдвэрлэл 188,9, тээвэр логистик экспорт 51,2, жижиглэн худалдаа 38,4, зах зээл хэрэглэгч 32,6 гэсэн утгатай байгаагаас харахад ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний хувьд дорвитой өөрчлөлт гараагүй байна.

Ноолуурын салбарын үйлдвэрлэл нь анхан шатны үйлдвэрлэл давамгайлсан, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо албан бус харилцаанд суурилсан нь нийлүүлэлтийн сүлжээ дэх тасалдлыг /gap/ бий болгож байгаа нь бодлогын бичиг баримтад түлхүүр үгийн тусламжтайгаар хийгдсэн шинжилгээний үр дүнтэй нийцтэй байна.

Манай улс дэлхийн ноолуурын түүхий эдийн 40 хувийг бэлтгэн нийлүүлдэг улс боловч малын тоо, тэр дундаа ямаан сүргийн тоо толгой сүүлийн 20 гаруй жил эрчимтэй өссөн нь бэлчээрийн доройтолд хүргэж байгаа билээ. Хэдийгээр манай орны цаг уурын нөхцөл байдал болон нүүдлийн мал маллагаа нь ноолуурын чанарт эергээр нөлөөлдөг боловч бэлчээрийн доройтлоос шалтгаалан монгол ноолуурын түүхий эд бэлтгэлийг байгальд ээлтэй гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь эргэлзээтэй байдалд хүргэж, монгол ноолуурын үнэ цэнд сөргөөр нөлөөлж байгаа томоохон хүчин зүйл юм.

Экспортын тоон үзүүлэлтээс харахад (Хүснэгт 2), дийлэнх ноолуураа угаасан байдлаар экспортолж байгаа нь нийлүүлэлтийн сүлжээний тасалдал нь төрийн бодлого дутагдалтай байгаатай хэсэгтэй давхардаж байна. Жишээлбэл: УИХ-ын 2022 оны 05-р сарын 05-ны 19-р тогтоолоор 2023 оноос хялгас ялгахас дээш боловсруулалт хийсэн ноолуурыг экспортолохоор тусгасан боловч энэхүү тогтоолыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2025 он хүртэл хойшлуулсан байна. Энэхүү шийдвэр нь манай улс угаасан ноолуурыг дараагийн 2 жилд экспортолсон хэвээр байх ба алдагдсан боломж нь 2022 оны үнийн дүнгээр бодоход жилд 318 сая ам.доллар байхаар байна.

Энэхүү судалгааг түлхүүр үгийн тусламжтайгаар тоололт хийхээс гадна, бодлогын бичиг баримтуудад агуулгын хэмжээнд тусгагдсан зорилтуудын шинжилгээг давхар хийсэн ба үр дүн ижил байгаа нь дараах дүгнэлтийг хийх боломжийг бүрдүүлж байна. Нэгдүгээрт, бодлогын баримт бичгийн агуулгын шинжилгээг түлхүүр үгийн тусламжтайгаар хийх боломжтой байна. Хоёрдугаарт, ноолуурын салбарт төрөөс барьж буй бодлого нь нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь авч үзэх хэрэгтэй ба бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо болон хэрэглэгч, зах зээлийн талаар цогц бодлогыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг нэмүү өртөг шингэсэн,

эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцыг түргэсгэнэ гэж дүгнэж байна. Аж үйлдвэрийн кластерт суурилсан бодлого хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байгаа манай орны хувьд төрөөс баримталж буй хөгжлийн бодлого нь үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шууд нөлөөтэй харж болохоор байна. Цаашид энэхүү судалгааг бодлогын бичиг баримтын үйл ажиллагааны нарийвчилсан хөтөлбөр, санхүүжилтийн мэдээлэл болон үр дүнгийн гүйцэтгэлд шинжилгээ хийх боломжтой юм.

Ашигласан материал

- Батбаяр, Д. (2019). *Ноосны анхан шатны боловсруулалтын технологи*.
- Батдэлгэр, Н., Кавано, Ё., Ясүэ, Х., & Сонинтамир, Н. (2016). Монгол улсыг хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын үнэлгээ, тулгамдаж буй асуудлууд. *Эдийн засаг сэтгүүл*, 12-17.
- Chih-Yuan Chu, Kijung Park, Ыл Е. Kremer, Applying Text-mining Techniques to Global Supply Chain Region Selection: Considering Regional Differences, *Procedia Manufacturing*, Volume 39, 2019, Pages 1691-1698, ISSN 2351-9789, <https://doi.org/10.1016/j.promfg.2020.01.271>. (<https://www.sciencedirect.com/science/article/pii/S2351978920303358>)
- Chopra, S. (2018). *Supply Chain Management: Strategy, Planning, and Operation (7th Edition)*. Pearson.
- Hugos, M. H. (2018). *Essentials of Supply Chain Management*. Wiley.
- Xu, N.; Zhou, X.; Guo, C.; Xiao, B.; Wei, F.; Hu, Y. Text Mining Applications in the Construction Industry: Current Status, Research Gaps, and Prospects. *Sustainability* 2022, 14, 16846. <https://doi.org/10.3390/su142416846>
- Wu, F.; Tang, Y.; Lin, C.; Zhang, Y.; Xu, W. Knowledge Trajectories Detection and Prediction of Modern Emergency Management in China Based on Topic Mining from Massive Literature Text. *Sustainability* 2022, 14, 16675. <https://doi.org/10.3390/su142416675>
- T. Zhang, M. Liu, C. Ma, Z. Tu and Z. Wang, "A Text Mining based Method for Policy Recommendation," 2021 IEEE International Conference on Services Computing (SCC), Chicago, IL, USA, 2021, pp. 233-240, doi: 10.1109/SCC53864.2021.00036. <https://ieeexplore.ieee.org/document/9592396>

Хууль, бодлогын баримт бичгүүд:

УИХ. (2015). *Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль*. Retrieved from <https://www.legalinfo.mn/law/details/11484>

УИХ. (2019). *Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*. Retrieved from <https://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>

УИХ. (1992). *Монгол Улсын Үндсэн Хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/367>

Цахим эх сурвалж:

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Retrieved from <https://legalinfo.mn/mn>

Үндэсний статистикийн хороо. Retrieved from <https://www.1212.mn/>

Гаалийн ерөнхий газар. <https://www.customs.gov.mn/>

ХААБ. (2019). *Хөдөө аж ахуйн бирж*. Retrieved from <http://www.mse.mn/n/menu/20>

ХХАХҮЯ. (2019). *Ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, салбарыг хөгжүүлэх эрх зүйн үндэслэл*. Retrieved from *Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудас*: <http://mofa.gov.mn/exp/blog/11/175>

МННХ. (2019). *Ноолуурын салбарын үйлвэрчдийн хүчин чадал*. Retrieved from: <https://ikon.mn/opinion/1o51>

Masatoshi Tamamura. (2002). *Policy Evaluation*. Retrieved from: <http://web.sfc.keio.ac.jp/~tama/policynet-hyouka.html>

Ministry of Education, Culture, Sports, Science and Technology-Japan. (2009). *Direction of R&D Evaluation System Reform*. Retrieved from: https://www.mext.go.jp/a_menu/kagaku/hyouka/1289630.htm